

"Гоё" тараг, "Гоё" технологи

2014 оны 2 сарын 28

Үндэсний үйлдвэрлэгч "Витафит" группийн охин компани "Оргил хүнс" ХХК-ийн үйлдвэрлэдэг "Гоё" таргийг Хятадад үйлдвэрлэн галт тэргээр оруулж ирдэг гэх мэдээлэл гэрэл зургийн хамт сүүлийн хэд хоног цахим ертөнцөөр таран иргэдийн бухимдлыг төрүүлээд байсан юм.

Тэгвэл "Оргил хүнс" ХХК-ийн зүгээс энэ бол ташаа мэдээлэл гэдгийг албан ёсоор мэдэгдсэн бөгөөд өчигдөр хэвлэл мэдээллийнхэн болон иргэдийг "Гоё" тарагны үйлдвэртэй танилцуулж, ямар шат дамжлагаар үйлдвэрлэгдэж хэрэглэгчдийн гар дээр очиж байгаа процессийг танилцууллаа. Өөрөөр хэлбэл, "Оргил хүнс" ХХК-ийн "Гоё" тарагны үйлдвэр өчигдөр хүн бүрийн өмнө нээлттэй байсан юм.

Манай сурвалжлах баг ч мөн адил Хан-Уул дүүрэгт байрлах "Оргил хүнс" компанийн үйлдвэртэй танилцлаа.



Хүүхэд, томчуудгүй амтархан хэрэглэдэг "Гоё" таргийг үйлдвэрлэдэг "Оргил хүнс" ХХК-ийн үйлдвэр нь ерөнхий хоёр хэсэгтэй юм байна. Эхний хэсэгт таргийг бүрж, дараагийн хэсэгт таргийг савлаж гаргана. Тус үйлдвэр ариун цэвэр болоод эрүүл ахуйн шаардлагыг дээд зэргээр хангаж ажилладаг юм билээ.

Тараг бүрэх, сүү авах, тараг савлах тоног төхөөрөмжүүдийг хүчил шүлт, цэвэршүүлсэн ус зэрэг таван давхар шүүлтүүрээр ариутгадаг аж. Тараг бүрэхээс эхлээд савлах хүртэлх бүхий л үйл ажиллагаа стандартын дагуу том суурин машинуудаар дамждаг учраас гадны бохирдол болон хүний гарын оролцоо тэр бүр орохгүй эрүүл ахуйн нарийн дэглэм дор бүтдэг. Мөн бидний өдөр тутмын хэрэглээ болсон "Гоё" таргийг Дани Улсын "Хансен" брэндийн хөрөнгөөр бүрж хийдэг бөгөөд энэхүү хөрөнгөө нэг л удаагийн исгэлтэд ашиглан технологийн горимын дагуу таргаа бүрдэг учраас чихэргүй таргийг 14, чихэртэй таргийг 28 хоног хадгалах горимтойгоор үйлдвэрээс гардаг тухай ч дуулгалаа. Өөрөөр хэлбэл, таргийн хадгалалтын хугацааг уртасгах ямар нэгэн нэмэлт бүтээгдэхүүн хийдэггүй гэнэ.

Хүмүүсийн дунд тус үйлдвэрийг хуурай сүүгээр "Гоё" таргийг үйлдвэрлэдэг гэсэн яриа бий. Тэгвэл биднийг очиход Хэнтий аймгаас ирсэн сүүний машинаас сүүгээ хүлээн авахтай таарсан юм. Тус үйлдвэрт лацадсан үнээний шингэн сүү Хэнтий аймгийн Хэрлэн сум, Өлзийт тосгонд "Атарчандгана" сүүний фермээс ирдэг юм байна. Сүүг нэг өнжөөд 5 тоннын сүүний машинаар зөөвөрлөн авчирдаг аж.

Тус үйлдвэрийнхэн "Атарчандгана" сүүний фермийг 2010 онд үйлдвэрийнхээ сүүний хэрэгцээнд зориулан байгуулж, өдгөө 450 гаруй сүүний чиглэлийн алаг тарлан, шилмэл үүлдрийн үнээтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа аж. Цаашид үнээнийхээ фирмийг өргөтгөж, 1000 үнээтэй болох төлөвлөгөөтэй байгаа гэсэн.


Мөн иргэдийг хамгийн их эргэлзүүлдэг "Гоё" тарагны савыг энэ л үйлдвэрт хийдэг юм байна. Тэд түүхий эдээ гадаадаас аван өөрийн үйлдвэрт гурван том суурь машинаар 1.5 литр, 1 литр, 450 граммын савыг үйлдвэрлэнэ. Энэхүү том суурин машинуудыг дэлхийн стандартын дагуу эрүүл ахуйн шаардлага хангасан, байгальд хор нөлөөгүй, хүнсэнд хэрэглэх түүхий эдээр "Оргил хүнс"-ийнхэн үйлдвэрлэдэг учраас савны хэлбэрийг солих ямар ч шаардлагагүй аж. Иргэд зөвхөн Хятадад л яг ийм савлагаатай тараг байдаг юм шиг ярьдаг ч үнэндээ Солонгос, Орос гээд дэлхийн улс оронд яг ийм савлагаатай тараг, сүүг та захын ямар ч дэлгүүрийн лангуун дээрээс харж болно. Тэгэхээр тэд дэлхийн стандартын дагуу савыг эх орондоо үйлдвэрлэдгээрээ мөн онцлогтой. Ингэж өөрсдийн хүч хөдөлмөрөөр бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж байхад андуу ташаа мэдээлэл, зохион байгуулалттайгаар олон нийтийн сүлжээгээр цацаж байгаад харамсаж байгаагаа "Оргил хүнс" ХХК-ийнхэн хэлж байлаа. Тиймдээ ч өөрсдийнхөө үйлдвэрийг танилцуулах нээлттэй хаалганы өдрийг ихэнхү зохион байгуулжээ.

ШИНЭ МЭДЭЭ | ИХ УНШСАН | ИХ СЭТГЭГДЭЛТЭЙ

- 153.5 тэрбум төгрөгийн ТБҮЦ арилжаалав
1 цаг 45 минутын өмнө
- Монгол Улсыг дахин бонд гаргана гэв
Өнөөдөр 17 цаг 30 минут
- Махны үнэ 1.2-8.7 хувиар өсчээ
Өнөөдөр 13 цаг 40 минут
- Mongolian Mining Corporation 2013 оны үр дүнгээ танилцууллаа
Өнөөдөр 13 цаг 3 минут
- Бондын талаар нээлттэй сонгол зохион байгуулна
Өнөөдөр 12 цаг 55 минут
- Азийн хөгжлийн банкнаас 20 сая долларын хөрөнгө оруулалт хийхээр боллоо
Өнөөдөр 12 цаг 4 минут
- Долларын ханш урт хугацаандаа л суларч магадгүй
Өнөөдөр 11 цаг 55 минут
- Хөтөчтэй ч хүн багатай ТҮЦ машинууд
Өнөөдөр 11 цаг 48 минут
- Хөгжлийн зөв стратеги үгүйлэгдэж байна
Өнөөдөр 11 цаг 43 минут
- Хөгжлийн зөв стратеги эдийн засгийг өсгөдөг
Өнөөдөр 8 цаг 3 минут
- 888 төсөл ба Монголын үйлдвэрлэл
Өнөөдөр 7 цаг 30 минут
- Дотоодын үйлдвэрлэгчид долларыг "гуйх" биш "үйлдвэрлэх" цаг хэзээ ирэх вэ
Өчигдөр 11 цаг 48 минут
- Чех улс хөрөнгө оруулах хүсэлт гаргалаа
2014 оны 3 сарын 15
- Азийн хөгжлийн банк Монголд хөрөнгө оруулна
2014 оны 3 сарын 15

Улаанбаатарт 1 хэм дула...

USD	1752.0	153.5 тэрбум төгрөгийн Т...
EUR	2415.0	
GBP	2871.0	
RUB	45.9	



ХАМГИЙН ИХ

- Т.Наран: Аль болох бага нүүрс зарж, их ашиг олох хэрэгтэй
- О.Дашбалбар агсны сүүлчийн шүлэг
- "Гоё" тараг, "Гоё" технологи
- Нэн ядуу өрхийн хүүхдүүдэд бэлэг өгнө



“Оргил хүнс” ХХК-ийн захирал Н.Батзаяатай уулзахад тэрбээр “Сүүлийн үед хэвлэлээр ташаа мэдээлэл гарсан. Үүнд нэгдсэн байдлаар үнэн бодит мэдээлэл өгөхөөр бид хэвлэлийн бага хурал хийн, өөрсдийн үйлдвэрийн үйл ажиллагааг нээлттэйгээр танилцуулж байна. Тэрхүү зургийг вокзалын “Ногоон зоорь” дээр дарсан бөгөөд “Барс” захын бизнес эрхлэгч Сайншанд руу ачуулж байсан бараанууд байсан. Бид үүний бүх баримтыг баталгаажуулж авсан. Мөн бидний зүгээс мэргэжлийн хяналтын газар, гаалийн байгууллагуудад хандаж яг манайх шиг таргийг гаднаас оруулж ирдэг үү гэсэн лавлагааг авахад ямар ч тийм бүтээгдэхүүн бүртгэгдээгүй байсан. Тийм учраас хэрэглэгчид маань эргэлзэх зүйлгүйгээр эрүүл мэнд, өдөр тутмын хэргэлэндээ зориулсан манай “Оргил” хүнс” ХХК-ийн “Гоё” таргийг хэрэглэж болно гэдгийг баттайгаар хэлэх байна” хэмээн онцолсон юм.

Г.Даша | Гэрэл зургийг М.Гантулга



- Хэнтий аймгийн "Атарчандгана" сүүний фермээс 5 тоннын энэхүү сүүний машинаар долоо хоногт 3-4 удаа шингэн сүү ирдэг -



- Тараг савлагдахын өмнөх дамжлага -

- Сураггүй болсон онгоцонд Монголыг зорьсон хоёр ч зорчигч байжээ
- Найз бүсгүйгээ бүлэглэн хөнөөв үү
- Хүчирхэг эмэгтэйчүүдээс асуух 5 асуулт
- АНУ-ын чаргачин хаалгаа цөм



- Тараг энэхүү танкинд бүрэлдээд тусгай хоолойгоор цааш дамжин савлагдана -



- Танк бүрээс авсан тарагны дээж -



- Тарагныхаа савыг өөрсдөө үйлдвэрлэдэг -



- Савлагдаад бэлэн болсон тарганд энэхүү төхөөрөмж үйлдвэрлэсэн он сарыг нь автоматаар дарна -



- Тараг бүрэх, сүү авах, тараг савлах тоног төхөөрөмжүүдийг хүчил шүлт, цэвэршүүлсэн ус зэрэг таван давхар шүүлтүүрээр ариутгадаг -



Eagle.mn таалагдсан бол: Like < 5k

Энэ мэдээллийг түгээх:

Like < 40

Tweet < 13

СЭТГЭГДЭЛ: (24)

Таны нэр:

Сэтгэгдэл бичих хэсэг:

hulan

za da huurai suugeer hiideg gedeg n unen bhaa, bi bol neeh itgeghui l bn,amt ni dajgui ch, tsaanaa l neg jinhene shingen suugeer hiisen tarag shig baidaggui,

Өчигдөр 19 цаг 3 минут

Puk

zarim 1 humusd heleh ug bna.yum hijj bga negendee bitgii hatuu ug helee.naad zaluug chin bi sain meddeg yum.onlon jil zutgej baij mongolchudin durtai taragiig gargaj irsen yum shuu.biznesin ner hundig n unagah gesen ursuldugchdin yavulga biz de.

shudarga hudlaa yaridaggyi unench tiilm l er hun.Zayadaa amjilt husie

2014 оны 3 сарын 4

БУСАД ФОТО



"Grand People 2013" шилдгүүдээ нэрлэлээ



"Эх орон Тусгаар тогтнолын эзэд" ёслолын арга хэмжээ боллоо



Монголын эмэгтэй архитекторууд "Хос жигүүр"-т

иргэн

Гоё тарагны түүхий эд болох сүүг яг хаанаас нийлүүлдэг нь харагдаагүй хятад хуурай сүүгээр хийдэг гэдэг нь ортой л байх, манай хүнсний үйлдвэрүүд үйлдвэрлэлийн процесс, түүхий эд авч байгаа шат дамжлагаа харуулах хэрэгтэй, хэл ам гарсны дараа биш нээлтээ хийхдээ л үзүүлэх хэрэгтэй. Зөв аарцны үйлдвэрлэл ч гэсэн нэг л ойлгомжгүй юм л харуулаад байсан.

2014 оны 3 сарын 3

Хариулах

Зочин

Үндэсний үйлдвэрлэгчээ дэмжих хэрэгтэй. ямар архи пиво үйлдвэрлэж хүмүүсийг хордуулж байгаа биш, сайхан цагаан идээгээрээ бизнес хийхэд юу нь болохгүй гэж. ааруул, эзгий цөцгий гээд бүгдийг нь үйлдвэрлэх хэрэгтэй шүү танайх

2014 оны 3 сарын 2

Хариулах

Зочин

за даа , зах зээлээс хойш манай бүх юм л хулхи , худлаа болсон шү дээ. яс технологиго бариад , хариуцлагатай ажиллаж чадаж байгаа болуу даа , мэдэхгүй. тэрнээс гадна энэ мөнгө цагаан нүд улаан болсон бизнесмэн нэртэй нөхдүүд дандаа худлаа ярьдаг , гаднаас авчирсан ямар юм хольж найруулдаг юм бүү мэд

2014 оны 3 сарын 1

Хариулах

eegii

Undesnii uildveriin fresh buteegdehuunee songotsgoe. Amttai haragdjaj bna shuu

2014 оны 3 сарын 1

Хариулах

!!!!

sain harval bugd shine tonog tohooromj!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!

2014 оны 3 сарын 1

Хариулах

Зочин

ugaasaa l shine tonog tohooromj bailgui dee, komiissin baraa avchrahgui bailgui

Нийтлэх

Good marketing

Sain marketing bna, uursduu shuum degdeegeed араас ni baahan hevleelin hural, залрулга nertei unegui reclam... Esvel sohorson bish zavshiv gegch bolov uu?

2014 оны 2 сарын 28

Хариулах

Зочин

hujaa mongol gedeg chin chi l bnda. iimerhuu sanaanda barigdaad bur yum bolgoniig ingej ***** bolgoj harj amidrahaar nutag ruu gaa ochvol yasim de..

Нийтлэх

Гоё гоё

Юун гоёын

2014 оны 2 сарын 28

Хариулах

Зочин

Undesnii uildverlegchdee demjiitsgeey

2014 оны 2 сарын 28

Хариулах

Зочин

Goy tarag uildvereesee yg heden togrogoor gardag ym be ene талаар medeelehgui yasiin bol? delguurt lav aimar unetei bdgiishdee

2014 оны 2 сарын 28

Хариулах

Зочин

ersdeltei l alham hij dee, hamag nuutsaa zadlaa haytsan bn shdee

2014 оны 2 сарын 28

Хариулах

Зочин

Ийм савалгаатай тараг бол хаа сайгүй байдаг ш дээ. Угаасаа яаж ч бодсон ийм их үйлдвэрлэлийн техник хэрэгсэл авчихаад хятадад таргаа оруулж ирнэ гэж юу байхав дээ. дотооддоо үйлдвэрлэсэнээс илүү зардал гарна ш дээ

2014 оны 2 сарын 28

Хариулах

Ижилхэн байна лээ

Сайн мэдэхгүй л юм гэхдээ Бээжинд явж байхад Гоё тараг Жүржийн талст бол яаг 100% ижилхэн байдын байна лэ би андуураад авах гэтэл бичиг нь бүгд Хужаа дээр байдаг болхоос яг л манайд

нэгджээ



Паралимпод Оросууд тэргүүлж байна



Орчин цагт өрнөсөн "Бремен хотын хөгжимчид"-ийн түүх



Т.Дэлгэрмөрөн "Гэрэлт үзэсгэлэн гоо"-г дэлгэлээ



Ноён Жуаны эмгэнэлт төгсгөл



Сонирхолтой гэрэл зургууд

байгаа Гоё тараг Жүржийн таслт байна байна

2014 оны 2 сарын 28

Хариулах

Зочин

delhniin brend bolson buteegdehuunuudiig uildwerleh erhiig ni awwaad mongoldoo uildwerlej bgaa yum

Нийтлэх

Зочин

гоё гоё

2014 оны 2 сарын 28

Хариулах

zochin

Бизнес этикгүй, хорон өрсөлдөөнийг Үнэнээр давж байгаа Гоё тараг-ны хамт олонд амжилт хүсье

2014 оны 2 сарын 28

Хариулах

ЗОЧИН

МИНИЙ ХҮҮХДҮҮДИЙН ХАМГИЙН ДУРТАЙ ТАРАГ НЬ

2014 оны 2 сарын 28

Хариулах

Зочин

эдний эсрэг мэдээлэл гаргаж хуурамч зураг эвлүүлж цацсан гарууд нь хэн байгаа бол.ашиг сонирхолын зөрчилтэй болохоороо л ингэж байгаа байлгүй дээ.өрсөлдөгч компаниуд нь юу юу байдаг юм бол оо?

2014 оны 2 сарын 28

Хариулах

Зочин

ТАМЫН ТОГООНЫ ҮЛГЭР Л БАЙХГҮЙ ЮУ ДАА

2014 оны 2 сарын 28

Хариулах

Зочин

za za,huurai suu muugeer hiideg gesen gesen hudlaa l ym bn shdee.manaihan negnihee hiji bgaa biznesiig yahaaraa dandaа ingej muuldag bnaa

2014 оны 2 сарын 28

Хариулах

Зочин

zayadaa amjilt husie.

2014 оны 2 сарын 28

Хариулах

Эхлэл

Шинэ Мэдээ
Нэг сэдвээр
Нийгэм
Эрэн сурвалжлах
Хууль эрх зүй
Бүтээн байгуулалт
Эрүүл мэнд
Боловсрол
Экологи
Орон нутаг
Таны гэр бүлд

Улс төр

Шинэ мэдээ
Тойм
Ярилцлага
Ерөнхийлөгч
УИХ
Засгийн газар
Гадаад харилцаа
Намууд
Сонгууль
Фото
Бусад
Видео

Спорт

Шинэ мэдээ
Хөлбөмбөг
Сагсан бөмбөг
Үндэсний бөх
Хурдан морь
Сур харваа
Бокс
Жүдо
Хөнгөн Атлетик
Усан сэлэлт
Фото
Видео

Энтертайнмент

Шинэ мэдээ
Хөгжмийн ертөнц
Кино урлаг
Оскар 2014
Дүрслэх урлаг
Театр
Утга зохиол
Ардын урлаг
Сонгодог урлаг
Style
Фото
Видео

Эдийн засаг

Шинэ мэдээ
Нийтлэл
Ярилцлага
Банк санхүү
Хөрөнгийн зах зээл
Үнэ ханш
Статистик
Уул уурхай
ХАА
Төсөв
Монгол брэнд
Бусад

Дэлхий дахинд

Шинэ мэдээ
Халуун цэг
Хөрш орнууд
Геополитик
Эдийн Засаг
Hi-tech
Шинжлэх ухаан
Экологи
Хүмүүс
Сонин содон
Бусад
Фото
Видео

Social news

Youtube
Twitter
Facebook
Blog



Eagle.mn 2013-2014 © Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан. Мэдээлэл хуулбарлах хоригтой.